

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

БАТЛАВ.
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л.НАСАНЦЭНГЭЛ

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Огноо: 2020.02.11

**СЭМҮТ-Д ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ПРОГРАММ, БАГАЖ, ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *СЭМҮТ-Д ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПРОГРАММ, БАГАЖ, ХЭРЭГСЭЛ
ХУДАЛДАН АВАХ*

Төслийн дугаар: *СЭМҮТ/202001003-02*
**Харьцуулалт/
гэрээний дугаар:** *СЭМҮТ-ТЕ-2020/03-02*

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 02 дүгээр сарын 11
СЭМҮТ-Д ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПРОГРАММ,
БАГАЖ, ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ
СЭМҮТ/202001003

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **СЭМҮТ-Д ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПРОГРАММ, БАГАЖ, ХЭРЭГСЭЛ** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Багц1. Интернет үйлчилгээ авах – 10,800,000 төгрөг

Багц2. Серверийн өрөөний хөргөлтийн систем -12,620,000 төгрөг

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно. Үнийн санал авах жишиг баримт бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/tender.gov.mn/ сайтаас авна уу. Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл нь 50.000 /тавин мянган төгрөг/ байна. Төлбөрийг цахим хэлбэрээр шилжүүлнэ

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 19-ны 10.00**-аас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02 дүгээр сарын 19** -ны өдрийн **10.30**-т нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

СЭМҮТ А байр 217 тоот

Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Г.Мөнхзаяа 88809996
munkhzaya111g@gmail.com

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2018, 2019 оны санхүүгийн тайлан, татварын тайлан</p> <p>Сүүлийн 2019 туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд:</p> <p>Багц1. Харилцаа холбоо Б ангиллын тусгай зөвшөөрөлтэй байх</p> <p>Багц2. Хөргөх бодис болон түүнийг агуулах тоног төхөөрөмжтэй ажиллах чадамжийн гэрчилгээтэй байх</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: УБ БЗД 9-р хороо 50-р гудамж СЭМҮТ А байр</p> <p>Давхар болон ерөөний дугаар: 2 давхар 217 тоот</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>

<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хугацаа дуусаагүй байх 2. Санхүүгийн тайлан: 2018 оны жилийн эцэс, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 3. Сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан эсэх шүүх, эрх бүхий байгууллагын тодорхойлолт 4. 2019 оны ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар 5. Ижил төстэй гэрээний үнийн дүн санал болгож буй үнийн 50 хувиас багагүй байх 6. 2019 оны борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх 7. Тендерт оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл 8. Шаардлагатай тусгай зөвшөөрөл; Багц1. Харилцаа холбоо Б ангиллын тусгай зөвшөөрөлтэй байх хугацаа дуусаагүй байх Багц 2. Хөргөх бодис болон түүнийг агуулах тоног төхөөрөмжтэй ажиллах чадамжийн гэрчилгээтэй байх 9. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцийн мэдээлэл 10. Гүйцэтгэгч нь зориулалтын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх; 11. Үйлчилгээг хэрэгжүүлэх хангалттай ажиллах хүчний нөөцтэй болохыг нотлох 2-аас доошгүй ажилтантай байх Багц1, Багц 2-т 12. Гүйцэтгэлийн үйлчилгээг үзүүлэгч нь мэргэжлийн үнэмлэхтэй, үйлчилгээнийхээ талаар бүрэн мэдээллийг өгөх чадвартай, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх бүрэн чадвартай, мэргэжлийн хүн байх ба мэргэжлийн үнэмлэхний хуулбар
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц1. Интернет үйлчилгээ авах Багц2. Серверийн өрөөний хөргөлтийн систем</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

БАГЦ 1 –ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

Барааны нэр:	Үзүүлэлт
Интернэтийн үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> 1. Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын аргууд-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм MNS-17799.2007 Монгол улсын стандартын шаардлага хангасан байх 2. Шилэн кабель буюу оптик холболтыг ашиглах 3. Dedicated хурдаар үйлчилгээ үзүүлэх /Өдөр шөнийн аль ч цагт бусад газарт шэйрлэхгүй байх/ 4. Гадаад хурд 25Mbps-с доошгүй байхаар сар бүр нийлүүлэх 5. Зурвасын өргөн Монгол улс дотроо буюу дотоод хурданд хурдны хязгаарлалтгүй байх 6. 8-аас багагүй public IP хаяг үнэгүй авах боломжтой байх 7. Онлайн сүлжээг ашиглан 24 цагийн турш өөрийн сүлжээний гадагшаа гарч буй мэдээллийн урсгалын хэмжээг хянах боломжтой хяналтын системтэй байх 8. Хэрэглэгчийн мэдээлэл татаж авах хэмжээнд ямар нэг хязгаарлалтгүй байх 9. Сүлжээний порт болон SMTP хязгаарлалтгүй 10. Интерпэйс конвертор хурд 1gb-с доошгүй байх 11. Захиалагч талд тоног төхөөрөмжүүд суурилуулах суурилуулалтын зардал нь үйлчилгээний үнэнд багтсан байх 12. Мэргэжлийн инженерийн тусламж, үйлчилгээ, зөвлөгөөгөөр хангагдах 13. Нөөц холболт /редундант холболт/ үүсгэх боломжтой байх 14. Шилэн кабелийн сүлжээний дэд бүтцийн нийлүүлэгч тал хариуцан өөрсдийн зардлаар хийх 15. Үйлчилгээ үзүүлэх компани нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх 16. VPN үйлчилгээг авах

1. **Стандарт:** Монгол улсын стандартын шаардлага хангасан. Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан.
2. **Баглаа, боодол:** Барааны чанар, стандартыг алдагдуулахгүй зориулалтын сав, хайрцганд хадгалагдсан байна.
3. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, 50 дугаар гудамж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, А блок, 211 тоот
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ


Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон
бараа нийлүүлэх хугацаа

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүлэх хамгийн эхний хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Интернэтийн үйлчилгээ	Дээрх үзүүлэлтийн дагуу	12	Сар	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, А блок, 211 тоот	2020.03.01	2021.03.01	

БАГЦ 2 – СЕРВЕРИЙН ӨРӨӨНИЙ ХӨРГӨЛТИЙН СИСТЕМ

1. Барааны тодорхойлолт:

Барааны нэр:	Үзүүлэлт
Серверийн өрөөний хөргөлтийн систем	<ol style="list-style-type: none"> Өрөөний хэмжээн 22м2 талбайг хөргөх 3 rack бүхий төхөөрөмжүүдтэй, техникийн зориулалтын шалтай серверийн өрөөний зориулалтын хөргөлтийн системийг суурилуулах -30°C эсвэл -45°C хүртэл 24C 50: 365 хоног ажилллах, өдөрт 24 цаг ажиллах Total capacity kW8.30 багагүй Sensible capacity kW 7.90 багагүй Хөргөх чадал 8-20kw Хөргөх бодис 410A Доороос үлээдэг байх Дээрээс үлээдэг байх Цахилгаан хангамж 220V 1ph 50Hz 380v 3Ph 50Hz <ul style="list-style-type: none"> Суурилуулалт, баталгаат засвар Үйлчилгээ үзүүлэх компани нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй байх Мэргэжлийн инженерийн тусламж, үйлчилгээ, зөвлөгөөгөөр хангагдах Захиалагч талд тоног төхөөрөмжүүд суурилуулах суурилуулалтын зардал нь үйлчилгээний үнэнд багтсан байх



- Стандарт:** Олон улсын стандартын шаардлага хангасан. Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан.
- Баглаа, боодол:** Барааны чанар, стандартыг алдагдуулахгүй зориулалтын сав, хайрцганд хадгалагдсан байна. Усралт суурилуулалт хийж гүйцэтгэх
- Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, 50 дугаар гудамж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, А блок, 211 тоот
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Серверийн өрөөний хөргөлтийн систем	Дээрх үзүүлэлтийн дагуу	1	ш	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, А блок, 211 тоот	2020.03.01	2020.10.01	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

Тендерийн нийт үнэ

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1-3 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
Багц1. Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
Багц2. Ажил гүйцэтгэж дууссаны дараа ажлыг СЭМҮТ-ийн хүлээн авах ажлын хэсэг шалгаж хүлээн авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Багц1. Нийлүүлэгчийн барааны нэр, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
Багц2. Нийлүүлэгчийн барааны нэр, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, Зарлагын агт, Баталгааны хуудас, Ашиглалтын зааварчилгаа,
 - 2) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 3) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Багц1. 1жил
Багц2. 1-3 жил
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Багц1. Сар сардаа
Багц2. Урьдчилгаа 70%, 30% -ийг хэсэгчлэн олгож болно.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05%**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]